



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 162

Улаанбаатар хот

“Стандарт проперти групп” ХХК-ийг нэгтгэх,
“Баянбогд” ХК-ийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баянбогд” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 97,607 ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Стандарт проперти групп” ХХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,530,200 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нийт нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,627,807 ширхэг хувьцааг үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-г, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Баянбогд” ХК-ийн оноосон нэрийг “Стандарт проперти групп” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газрын дарга Т.Гандулам, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ангар, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Алдаржавхлан нарт үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Баянбогд” ХК /Г.Лхамсүрэн/-д үүрэг болгосугай:

1/ “Стандарт проперти групп” ХХК-ийг “Баянбогд” ХК-д нэгтгэсэнтэй холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөн байгуулах, нэгдэж буй компанийн өмчлөлийн эд хөрөнгийг “Стандарт проперти групп” ХК-д шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн болон оноосон нэрийн өөрчлөлт, шинэчилсэн дүрмийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, Хороонд ирүүлэх;

2/ 2015 оны эхний улирлын санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг тусгах;

3/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

000751

4/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газарт, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА